



**AERO MONGOLIA**  
The Leading National Airline




Суудлын тоо хязгаартай




**33-03-73**

**Улаанбаатар: Өдөртөө  
+16 хэм, шөнөдөө +11  
ХЭМ**




[Эхлэл](#)   [Эдийн засаг](#)   [Улс төр](#)   [Нийгэм](#)   [Гадаад мэдээ](#)   [Онцлох хэрэг явдал](#)   [Ярилцлага](#)   [Энтертайнмент](#)   [Хобби](#)


[Facelook](#)   [24 баримт](#)   [Солиотой 24](#)   [Видео](#)   [Хошин шог](#)   [Сээгс](#)
[Хайлт](#)




**Амьдрахад хамгийн тааламжтай хотоор Мельбурнийг нэрлэлээ**



**Хоёр уулзвар ашиглалтад орлоо**



**Өнөөдрөөс нэмэлт автобус үйлчилнэ**



**Дэлхийн хамгийн сонирхолтой усан сангууд**

## Өвөр монгол малчныг зодож хөнөөсөн хятадыг өмөөрч, Засгийн газар нь 500 мянган юань санал болгожээ

2013 оны 8 сарын 28



Өвөр Монголын Туг сумын Далан цэцэг тосгоны иргэн 58 настай Баянбаатарыг Хятадын төмөр замын ажилчид зодож, амь насыг нь хөнөөсөн хэрэг өнгөрсөн долоо хоногт гарсан. Хятадын төмөр замын ажилчид малын бэлчээр дайруулан төмөр зам тавих ажлаа эхлэх гэсэн ч малчдын эсэргүүцэлтэй тулгарсан аж. Тиймээс тэд мод, чулуугаар Баянбаатарыг цохиж амь насыг нь бүрэлгэсэн гэлээ. Ноцтой нь хэргийн газар дээр Хятадын цагдаа нар ирсэн ч нөхцөл байдлыг намжаагаад Баянбаатарын аминд хүрсэн хятад ажилчдыг баривчлалгүй явуулсан байна. Харин хохирогчийн гэр бүлийнхэн үүнд ихэд бухимдаж, Баянбаатарын амь насыг хохироосон этгээд хариуцлага тооцох ёстой гэж цагдаад хандсан. Энэ хэргийг харсан олон гэрч байгаагийн дээр хятад төмөр замчид Баянбаатарыг зодож буй зураг ч интернет сүлжээгээр олон нийтэд тараад байгаа юм.

Харин Нью-Йорк хотод төвтэй Өмнөд монголчуудын хүний эрхийн мэдээллийн төв (SMHRIC)-ийн мэдээлснээр Баянбаатарын аминд хүрсэн төмөр замчиныг цагдаагийнхан байцаагаагүй бөгөөд, Хятадын Засгийн газар хохирогчийн гэр бүлийнхэнтэй тохиролцохыг хүссэн байна. Тэдэнд

500 мянган юань буюу ойролцоогоор 82 мянган доллар өгөөд хэргийг хэрэгсэхгүй болгох санал тавьжээ. Хохирогчийн гэр бүлийнхэн, хамаатан садан нийлсэн 80 гаруй хүн оршуулах ёслолд оролцох үеэр цагдаагийнхан ирж, тэднийг хатуу хараа хяналтанд байлгажээ.

Энэ хэргийн талаар Өвөр Монгол болон Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийтлэх боломжгүй байгаа тул SMHRIC-ийн төлөөлөгч хохирогчийн бэр Чандмань гэх эмэгтэйтэй утсаар ярилцжээ.


- **Хохирогч Баянбаатарын амийг бүрэлгэсэн баримтуудыг Хятадын хуулийнхан үгүйсгэж байна. Түүнийг зүрхний өвчтэй байсан гэж мэдэгдсэн байсан. Энэ үнэний ортой юу?**

- Миний хадам аав маш эрүүл, саруул хүн байсан. Түүнд өмнө нь өвчтэй гэх ямар ч шинэ тэмдэг байгаагүй. Хятадууд түүнийг зодож, амь насанд нь хүрсэн гэдэг бол булзааруулах аргагүй үнэн.


- **Хэргийн газар дээр яг юу болсон юм бэ? Тодорхой хэлж өгөхгүй юу?**

- Бидний дунд маргаан үүсэхэд хятад төмөрч замчид “Та нарыг хутгалж ална” гэж сүрдүүлж байсан ч тэдэнд хутга эсвэл ямар нэгэн зэвсэг байгаагүй. Тийм болохоор хадам аавыг тэд атгасан гараараа маш хүчтэй цохиж, өшиглөж байсан. Ялангуяа тэр цагаан цамцтай хүн.


[Шинэ мэдээ](#)   [Их уншсан](#)   [Их сэтгэгдэлтэй](#)




**ДАХИН НЭГ ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛНА**  
Өнөөдөр 18 цаг 12 минут



**Казакстаны элчин сайдыг хүлээн авч уулзлаа**  
Өнөөдөр 17 цаг 54 минут




**Политехник коллежид 800 оюутан суралцана**  
Өнөөдөр 17 цаг 26 минут



**“Амьтны тухай” хуулийн хэрэгжилтийг шалгаж байна**  
Өнөөдөр 17 цаг 24 минут



**“Стратегийн удирдлага, төлөвлөлт” сэдэвт сургалт эхэллээ**  
Өнөөдөр 17 цаг 21 минут



**“МОМО-3” төслийг хэрэгжүүлэхээр болжээ**  
Өнөөдөр 17 цаг 11 минут

### Facelook



**Хичээл тасалж, хэрэг тарьдагаараа алдартай байсан хийлч Ч.Дэлгэрцэцэгийн фото түүх**

- **Зодоон болох үеэр цагаан цамцтай хүн гараар атгаад дайрч байгаа зураг авсан байсан. Өөр нэг зураг дээр тэр хүн чулуу бариад хэн нэгнийг цохиж байсан. Тэр хүн мөн үү?**

- Тийм ээ, тэр хүн чинь алуурчин. Гэхдээ тэр чулууг өөр малчин руу шидсэн ч азаар бултаж чадсан. Миний аав тэр хүний гарт өртсөн. Нөхөр маань аавыг босгох гэж оролдсон ч босч ирээгүй. Тиймээс аавыг эмнэлэгт яаралтай хүргэх гэж оролдсон ч хятад төмөр замчид зам хааж зогсоод 30 минут орчим явуулаагүй.

- **Яагаад ийм зодоон үүссэн юм бэ?**

- Бид бэлчээр газраа хамгаална гэж эсэргүүцэхэд хятадууд бүгдээрээ уурлаж, бид нар руу дайрч, давшилцгаасан. Аавын аминд хүрсэн хүн бусдыгаа машинаас хутга авчрахыг шаардаад "Би бүх монголчуудыг нэг нэгээр нь алах болно" гэж хашгирч байсан.

- **Засгийн газар, цагдаагийнхан та нарт ямар хариу өгч байна? Хэргийг мөрдөх талаар хариу өгсөн үү?**

- Үгүй ээ, хэргийг мөрдөх талаар хэн ч, нэг ч үг дуугараагүй. Ах дүү, хамаатан садан нийлсэн 80 гаруй хүн оршуулгын ёслол дээр байхад цагдаа нар ирж, биднийг гарахыг шаардсан. Биднийг утсаа хаахыг шаардаж, ариун цэврийн өрөө ороход хүртэл цагдаа нар дагасан. Ингэж бидний эрх чөлөөг, хааж боосныхоо дараа Засгийн газар бидэнтэй наймаалцахыг хүссэн. Тэд энэ хэргийг чимээгүй өнгөрөөвөл 500 мянган юань өгье гэсэн. Бид бол нүүр нүүрээ харж байгаад "ямар ч тохиролцоо байхгүй" гэдгээ хэлсэн. Алуурчин хийсэн хэргийнхээ төлөө шүүгдэх ёстой. Бид тэдэнд монголчууд хэзээ ч хүний амийг мөнгөөр хэмждэггүй гэдгийг хэлмээр байна. Одоо шударга ёс л хэрэгтэй. Алуурчин зохих шийтгэлээ амсаж, Хятадын Засгийн газар биднээс уучлал гуйхыг л хүсч байна. Ийм хэрэг зөвхөн манай гэр бүлд тохиолдоогүй. Олон өвөр монголчууд ингэж хохирогч болж байгаа шүү дээ.

- **Засгийн газар та нартай тохиролцохыг хүссэн гэлээ. Яг ямар албан тушаалтай хүмүүс тохироо хийхээр ирсэн юм бэ?**

- Уушийн хошууны захиргаа болон Засгийн газраас ирсэн хүмүүс.

- **Энэ хэрэгтэй холбоотойгоор хэд хэдэн өвөр монгол хүнийг баривчилсан гэж сонслоо?**

- Тийм ээ, би ч бас сонссон. Гэхдээ яг хэдэн малчинг баривчилсан тоог мэдэхгүй байна. Манай сумын малчдыг аавын үхэлтэй холбоотойгоор байцааж, цагдаагийнхан баривчилсан гэсэн.



Даян аварга Г.Өсөхбаярын анхны шагнал ногоон цай, шар дэвтэр

## 24 Баримт



Зун цагт хийж болох 24 зүйл



"Монголын шинэ дива" гэгдэх дуучин Ч.Цэлмүүний тухай 24 баримт

## Зохиогчийн булан



**Ж.Золбаяр**  
Цэргийн хоол




**М.Ичинноров**  
Багш таньд хэлэх үг байна



**Г.Мөнхсүх**  
Шинэчлэлд нас чухал уу?



**Ч.Мөнхбаяр**  
Израилийн талаарх бидний төсөөлөлд үнэн юм бий юу?









Т.Гэрэл

Манай сайт танд таалагдаж байвал LIKE хийгээрэй. Танд баярлалаа.

Like You, Batnasan Davaasambuу and 25,230 others like this.

Follow @24tsag 3,549 followers

- Өвөр Монголчуудыг нутагт нь хятад иргэдийг олноор суурьшуулна гэсэн хуурамч мэдээлэл тараасан хэмээн шийтгэжээ
- 546 метр урт "Монголын нууц товчоо" Гиннесийн номд оржээ
- Зуу гаруй хятад өвөр монгол малчдын газрыг булааж, зоджээ
- Өвгөн зураачийн бийр алжаах өдий байна
- Ж.Самбуу даргын алтан цаг Өвөр Монголд байна

Бусад холбоотой мэдээг үзэх бол энд дар

Like 44 Tweet 11

**АНХААРУУЛГА:** Та сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууны хэм хэмээг хүндэтгэнэ үү. Хэм хэмжээ зөрчсөн сэтгэгдэлийг админ устгах эрхтэй.

Сэтгэгдэл: (8)		Хамгийн шинэ
Нэр: <input type="text"/> Сэтгэгдэл: <input type="text"/>		
Зочин (103.11.195.156) ( 2013 оны 8 сарын 29 ) udahgui bidnii tsag ireh biz dee	1	0
	Хариулт бичих	
ҮҮҮҮ (122.201.18.34) ( 2013 оны 8 сарын 29 )	1	0

Манайд ийм байдал үүсээд удаж байна шүүдээ.Мэргэжлийн хяналтын барилга дээр монголчууд цагдаа нартайгаа хамт зодуулсаныг арай л мартаж болоогүй баймаар юм.	Хариулт бичих
<b>сосорбарам</b> (182.160.35.152) ( 2013 оны 8 сарын 29 ) энэ худлаа мэдээлэл. манай хятад ах нар ингэхгүй.батүүл мундаг. ленин сүхбаатарыг бид авч хаянаа.	0 1 Хариулт бичих
<b>*****</b> (202.131.230.164) ( 2013 оны 8 сарын 28 ) muu ***** hujaa nar unen davartsan pizdanuu yumaa, buh mongolchuud geh shig	2 0 Хариулт бичих
<b>uvur mongol</b> (202.70.47.178) ( 2013 оны 8 сарын 28 ) baabar, bayartsogtyg chuluugaar tsohij alayaa	0 0 Хариулт бичих
<b>Зочин</b> (203.194.115.84) ( 2013 оны 8 сарын 28 ) Manaid iim yum bolnoo bolj bgaag nuugaad mongo ogdog ch baij magadgyi. Bayan olgiid yalaa daa	3 0 Хариулт бичих
<b>Зочин</b> (182.160.38.152) ( 2013 оны 8 сарын 28 ) удахгүй манайд ийм болно. ленин сүхбаатарыг хараагаад байдаг хүмүүс энийг л хүсээд байгаа юм шүү дээ.	2 0 Хариулт бичих
<b>удахгүй манайд болох</b> (122.254.127.34) ( 2013 оны 8 сарын 28 ) Ийм эмгэнэлтэй.даврсан зүйл удахгүй манайд болох бий дээ? Бага үндэстнүүддээ хятадууд яаж ханддагийн жишээ байна..	2 0 Хариулт бичих

[RSS](#)[Facebook](#)[Follow us on twitter](#)[Мэдээ](#)[Хамаг Монгол](#)[24 дүгээр сувар](#)

Сурталчилгаа байршуулах | Вэб сайт хийх | Холбоо барих | RSS  
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Мэдээлэл хуулбарлах хориотой.